



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/498

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5/а/, 29.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8 заалт, Монгол улсын Засгийн газрын 303 дугаар тогтоолоор батлагдсан "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.11.2 заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сэтгэц, зан үйлийн эмгэгийн бууруулах, өвчин хурцдаж хэвтэн эмчлэх үйл явцыг багасгах зорилгоор сэтгэцийн архаг өвчтэй иргэдэд нийгэм хамт олныг түшиглэн сэтгэц, нийгмийн нөхөн сэргээх өдрийн эмчилгээг "Оюу-Орхон" ХХК-ний "Оюу" сэтгэц наркологиин хувийн хэвшлийн ортой эмнэлэгтэй 2017 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын хугацаанд хамтран зохион байгуулж, төрийн зарим үйлчилгээг гүйцэтгүүлсүгэй.

2. Шаардагдах 2000000 /Хоёр сая/ төгрөгийг "Сэтгэцийн архаг өвчтэй иргэдэд нийгэм хамт олныг түшиглэн сэтгэц, нийгмийн нөхөн сэргээх өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/, Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
08 дугаар сарын 27-ны өдрийн
1/20 дугаар захирамжийн хавсралт



**СЭТГЭЦИЙН АРХАГ ӨВЧТЭЙ ИРГЭДЭД НИЙГЭМ ХАМТ ОЛНЫГ ТҮШИГЛЭН
СЭТГЭЦ, НИЙГМИЙН НӨХӨН СЭРГЭЭХ ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭНД
ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Тоо ширхэг	1 бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Өдрийн хоол /1 сард 6 хүн нийт 4 сард 24 хүн /	24	2500	1800 000
2	Хөдөлмөрийн дадал олгох сургалт/ оёдол, албан бичгийн дугтуй хийх/, /4 сар/	1 сард	35000	140 000
3	Хөдөлмөрийн дадал олгох сургалт/ оёдол, албан бичгийн дугтуй хийх/, /4 сар/	4 сар	10000	60000
4	Нийт			2 000 000